

С. БУЯННЭМЭХ СУДЛАЛЫН АНХНЫ ХУУДАС

Ван Мандуга¹

Түлхүүр үг: С. Буяннэмэх, орчин үеийн уран зохиол, уран үгсийн чуулган, уран зохиолч

Товч агуулга: Тус өгүүлэлд 1929 онд хэвлэгдсэн “Уран үгсийн чуулган” хэмээх зохиолын эмхтгэлд Дунгарын Чимэдийн бичсэн “Оршил” болон 1935 оны үеэр бичигдсэн хамтын бүтээл “Түмэн ардын төлөөнөө соёлын бүтээлийг бүтээгч” хоёр өгүүлэлд задлалт шинжлэлт хийж, монголын орчин үеийн уран зохиолын үндэслэгчийн нэг, ууган зохиолч С. Буяннэмэх жич түүний уран бүтээлийн тухай судлалын анхан шатны байдлыг нэн нарийвчлан тодруулахыг хичээв.

Түлхүүр үг: С. Буяннэмэх, монголын орчин үе, уран зохиол, соёлын бүтээл

С.Буяннэмэхийн намтар түүх, уран бүтээлийн тухай шүүмж үнэлгээ, шинжилгээ судалгаа 20-р зууны 20-иод оны сүүлчээс эхэлжээ гэж үзэж болох юм. 1929 оны 12 дугаар сард хэвлэгдсэн монголын орчин үеийн уран зохиолчдын хамаг анхны зохиолын эмхтгэл болох “Уран үгсийн чуулган”²-ны оршилд зохиолч Дунгарын Чимэд³-ээс: “Энэхүү дэвтэрт бичсэн шүлэг зохиолын их төлвийг манай бүлгэмийг удирдан үүсгэгчийн нэгэн бөгөөд Монголын дотор яруу найруулга, шүлэг бичгийн зүйлд нилээд мэргэжсэн уран зохиолч нөхөр Буяннэмэхийн шүлэг зохиолууд болмой. Өдгөө үеийн шинэ хувьсгалын авьяас бүхий зохиолч залуучуудын дундаас нэн ялангуяа үндэсний байгалийг магтах ба хуучны дарлагдлын доторхи ядуу зүдүүгийн зовлон баян элбэгийн байдал мэтийг чимэгтэй уянгатай бөгөөд үнэнээр зохиохуйд тодорч буй уран зохиолч хэмээж болмой, Түүнээс гадна, шүлэг найруулгыг хэрхэн зохиох сэдэв сануулга болгож нөхөр Буяннэмэхийн бичсэн зүйлүүд нь шинэ зохиолч нарт үнэхээр тустай зөвлөгч болж чадах буй за хэмээн горилмой”⁴ гэж бичжээ. Энэхүү товчхон өгүүлэмжид, юуны өмнө тус эмхтгэлд орсон шүлэг зохиолын олонхи нь С. Буяннэмэхийн бүтээл болохыг

¹ Доктор, профессор. БНХАУ-ын Бээжингийн Төвийн Үндэсний Их Сургууль

² “Уран үгсийн чуулган” эмхтгэл, хувьсгалын уран зохиолч нарын бүлгэмээс хэвлүүлэв, 1929 оны 12-р сар

³ Дунгарын Чимэд (1904-1932) “Чимэд Дунгарын” гэж бичиж байгаа нь түүний нууц нэр. Монголын орчин үеийн ахмад зохиолч. 1928-1929 онд Москва хотноо дорно дахины хөдөлмөрчдийн коммунист их сургуульд суралцаж төгсчээ. МХЗЭ-ийн төв хорооны орлогч дарга, мал тариалангийн яамны сайд, Улаанбаатар хотын болон Төв аймгийн намын хорооны ерөнхий нарийн бичгийн дарга зэрэг тушаалыг урьд хожид хариуцаж байв. 1929 оны 1 дүгээр сард анхны хувьсгалын уран зохиолч нарын бүлгэмийг зохион байгуулах ажилд чухал үүрэг гүйцэтгэжээ. 1931 онд МАХН засгийн арван жилийн ойн баярын үед аж үйлдвэрийн гавьяан одонгоор шагнагджээ. Төлөөлөгч зохиол нь “Ангир шувуу”, “Зарц эмэгтэй Занданбал”, “Сумжид хэмээгчийн түшмэл явдал”, “Янагийн үнсэлт” гэх зэрэг буй.

⁴ “Уран үгсийн чуулган” эмхтгэл. 1929 оны 12-р сар, 4-5 дугаар нүүрт буй.

тодорхойлоод дараа нь С. Буяннэмэхийг “Манай бүлгэмийг удирдан үүсгэгчийн нэг”, “Монголын дотор яруу найруулга, шүлэг бичгийн зүйлд нилээд мэргэжсэн уран зохиолч”, “Шинэ хувьсгалын авьяас бүхий зохиолч”, залуучуудын дундаас нэн ялангуяа үндэсний байгалийг магтах ба хуучны дарлагдлын доторхи ядуу зүдүүгийн зовлон баян элбэгийн байдал мэтийг чимэгтэй уянгатай бөгөөд үнэнээр зохиохуйд тодорч буй уран зохиолч гэж өндөр үнэлж, С.Буяннэмэх бол хувьсгалын уран зохиолчдын бүлгэмийг удирдан үүсгэсэн зохион байгуулагч, уран сайхны авьяас чадвар бүхий ахуйч үзлийн уран зохиолч мөн гэж тодотгон тэмдэглэжээ. Гуравт, С. Буяннэмэхийн бичсэн “Уран зохиолын зүйлийг хэрхэн зохиох сэдэв” хэмээх өгүүллийн ач холбогдол, нөлөө үйлдлийг нотолж “Шинэ зохиолч нарт үнэхээр тустай зөвлөгч болж чадах буй за” гэж Буяннэмэхийн өгүүллийг шинэ залуу зохиолчдын зохиол туурвилд чухал жолоодомж болж чадна гэж үзсэн байна. Энэхүү оршил бол зохиолч С. Буяннэмэх жич түүний зохиол бүтээлийг судлан шинжилж, үнэлж дүгнэсэн анхны хуудас болно гэж үзэж болно.

Түүний дараа 1935 оны орчмоор бичигдсэн хамтын бүтээл “Түмэн ардын төлөөнөө соёлын бүтээлийг бүтээгч” гэх өгүүлэлд С. Буяннэмэх жич түүний уран бүтээлийн тухай тусгайлан шинжилж, түүнийг “Түмэн ардын төлөөнөө соёлын бүтээл бүтээгч”, “Үндэсний хувьсгалаар төрж гарсан олон залуу авьяастан ба зохиолчдын дотроос нилээд мэргэжсэн чадамгай зохиолч мөн болохын дээр манай монгол үндэсний хувьсгалын уран зохиолыг анх үүсгэн хөгжүүлэгч бөгөөд удирдагч нь мөн”⁵ гээд “Анхны уран зохиолч нөхөр Буяннэмэх нь хувьсгалт ёсны уран зохиол өчүүхэн ч дэлгэрээгүй монгол орны дунд анх удаа уран авьяасыг гаргаж элдэв сонин шүлэг найруулга зүйл бүрийн үлгэр өгүүллүүдийг бичиж гаргасан нь лавтай Монгол улсын уран зохиолчдын анхан үүсгэгч болж чадсан аж”⁶ гэж монголын орчин үеийн уран зохиолын ууган зохиолч, чадамгай зохиолч, үүсгэн хөгжүүлэгч, удирдан зохион байгуулагч тун бусдчаар зөв зүйтэй үнэлсэн байна. Энэ бол С. Буяннэмэх судлалын бас нэг чухал хуудас болох юм. Тус зохиолд зохиолч С. Буяннэмэхийн 1921 оноос 1935 он хүртэлх 14 жилийн дотор бичиж туурвисан уран бүтээлийг анхдугаар үе, хоёрдугаар үе, гуравдугаар үе гэж гурван үе шат хувааж, үе шат бүрийн уран бүтээлийн ур чадварын өсөлт, агуулга үзэл санааны ач холбогдол, гүн утга санаа, уран яруу хэл найруулга зэргийг ерөнхийд нь хураангуйлан авч үзжээ. Анхдугаар үе (бараг 1921-1928 он) дэхь уран бүтээлийнх нь тухай өгүүлэхдээ: “Энэ үед, залуу зохиолч нь зохиолын арга маягийг мэдэрч зохиож болохын замд эхлэн орсон бөгөөд тэр үед нөхөр Буяннэмэх өөрийн улсын дотор төдий л сайн зохиолуудыг гаргаж чадсангүй бөгөөд тэр үеийн “Үнэн” хэмээх сонинд хэвлэгдэж байсан зохиолуудыг нь авч үзвээс бага сага өгүүлэл зүйрлэлүүд, холбоо шүлгүүд болох бөгөөд тэдгээрийг өдгөөгийн Буяннэмэхийн зохиол лугаа харьцуулж үзвээс чанараар их л өөр болохын дээр Буяннэмэхийн уран авьяасын чадвар энэ хооронд хичнээн нэмэгдсэн нь аяндаан илэрхий болой”⁷ гэж С.

⁵ Монгол улсын нийтийн номийн сангийн монгол бичмэл номын хөмрөгт хадгалагдаж байгаа гар бичмэл эх, хамтын бүтээл, тодорхой зохиогчийн нэр байхгүй, бараг 1935 оны үеэр бичигджээ. Ван мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй” Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он. 21-26 дугаар нүүрт.

⁶ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй” Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он. 21 дүгээр нүүр

⁷ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он. 27 дугаар нүүр,

Буяннэмэхийн “Таван мөнгө хүрэхгүй үнээр түмэн ардаа худалдсан халхын ноёд” гэх мэт уран зохиолын анхны гараа болох бүтээлүүдийн урлаг уран сайхны чанар аанай байсан бөгөөд сүүлийн үед түүний уран авьяасын чадвар нь олон дахинаар нэмэгдсэн болохыг тоймлон өгүүлжээ. Залгаад С. Буяннэмэх барга ба дотоод монголд очиж тэндэх хувьсгалын ажилд туслалцаж дотоод монголын суртлын ба уран сайхны сэтгүүлийг 19 (1-9 дүгээр – эшлэгч) дүгээр хүртэл гаргаж байсан ба түүний дараагаар Дотоод монголоос эгэж ирээд буриад монголд уригдан очиж тэндэх багш нарын сургууль ба эрдмийн хүрээлэнд жил тойрон байхдаа буриад монголын [ийг] хэл бичгийн соёлтой болгон сайжруулахын төлөө оролдож байсан ба өөрийн анхан түрүүчийн сайн сайхан зохиолуудыг зохиосон тухай, бас тэнд байхдаа “Аюулт байлдааны чимээ”⁸, “Алсыг зорьсон алтан загас”⁹, “Нараны эргэлт”¹⁰ гэх зэрэг уран зохиолоо буриад монгол улсад “Уран үгсийн чимэг” гэх дэвтэрт хэвлэгдсэн тухай, бас зарим бүтээл нь буриад монголын эрдмийн хүрээлэнд хадгалагдаж хэвлэлд бэлтгэгдэж байгаа тухай, өөрийн улсын дотроо хэдэн ший жүжгийн зохиол бичиж туурвисан тухай С. Буяннэмэхийн намтар бүтээлд холбогдсон маш чухал бөгөөд үнэний үндэслэлтэй мэдээ баримт гаргажээ. Эндээс бид С. Буяннэмэхийн 1921-1928 он хүртэлх хугацаан дахь намтар түүх, үйл ажиллагаа ба уран бүтээлийн тухай баттай мэдээ баримтыг олж болох юм. Буриад монголын эрдмийн хүрээлэнгээс хэвлүүлэхээр бэлтгэж байсан тэр бүтээл нь бидний шинжилснээр буриад монголд хараахан хэвлэгдэж чадаагүй, монгол улсын утга зохиол судлагч эрдэмтэн Ш. Лувсанвандан крилл үсэгт хөрвүүлэн буулгаж, 1967 онд “Бор бор болжмор” гэх нэрээр Улаанбаатарт хэвлүүлсэн хүүхдийн өгүүллэгийн түүвэр “Багачуудын баясгалант бичиг”¹¹ болох ажээ. “Алсыг зорьсон алтан загас” хэмээх зохиолыг нь “уран найруулалын талаар маш эрхэм зохиолуудад тооцогдох бөгөөд гадаад дахины гайхамшигт соёл ба түүний [ийг] өөрийн улсдаа авчрахын тул халх орны туул голын “Цөл Гил” хэмээх загасаар зүйрлэж бичсэн болой”¹² гэж үнэлэн бичжээ.

⁸ С.Буяннэмэх “Аюулт байлдааны чимээ”, Буриад Монголын сэтгүүл “Уран үгсийн чимэг”-т 1937 онд нийтлэгдэж, 1929 онд “Уран үгсийн чуулган” зохиолын эмхтгэлд “Аюулт байлдаан” нэртэй нийтлэгдэв. 1934 онд хэвлэгдсэн “Монгол хэл бичгийн сайжруулах бодлогын өгүүлэл” (5-р дэвтэр)-д сонгон түүвэрлэхдээ “Аюулт байлдааны чимээ” гэх нэрээр нь нийтлэв. Ван Мандуга Д.Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (2 дугаар боть), Үндэсний хэвлэлийн хороо. 2009 он. 155-183 дугаар нүүр.

⁹ С.Буяннэмэх “Алсыг зорьсон алтан загас”, “Уран үгсийн чимэг”, 1 дүгээр дэвтэр, Буриад Монголын эрдмийн хүрээлэнгийн хэвлэл, 1927 он. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (2-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2009 он. 131-154 дүгээр нүүр.

¹⁰ С.Буяннэмэх “Нарны эргэлт”, “Уран үгсийн чимэг”, 1 дүгээр дэвтэр, Буриад Монголын эрдмийн хүрээлэнгийн хэвлэл, 1937 он. Ван Мандуга Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он. 66-68 дугаар нүүр.

¹¹ С.Буяннэмэх “Багачуудын баясгалант бичиг” гар бичмэл эх. 11 жижиг үлгэрээр бүрэлдсэн тус түүврийг Буриадын эрдмийн хүрээлэнгийн захиалгаар 1927 онд бичсэн бөгөөд 1931 онд хэвлэхээр бэлтгэж байсан боловч бусад зүйлийн шалтгаанаас болж хэвлэгдэж чадсангүй. С. Лувсанвандан 1965 онд Улаан үд хотноо эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бичмэлийн сангаас “Багачуудын баясгалант бичиг” түүврийг олж аваад бүгдийг крилл үсэгт буулгаж, ард нь “Алсыг зорьсон алтан загас” гэх зохиолыг нэмээд, 1967 онд жижиг товхимол болгон Улаанбаатарт хэвлүүлжээ.

¹² Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй” Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он. 23 дугаар нүүр

Хоёрдугаар үе буюу нугалаатны үе (бараг 1928-1932 он) дэх С. Буяннэмэхийн уран бүтээлийн тухай өгүүлэхдээ “Энэ үед үндсэн соёлыг хөгжүүлэх тухай хэргийг явуулсны үр нөлөө нь улсын соёл боловсролын хэрэгт нийтээрээ тусгасны дотор мөн нөхөр Буяннэмэхийн уран авьяас нь асгаран бургилан хөгжиж шинэ зохиолын зүйлүүдийг зохиож чадсангүй бөлгөө. Гэвч энэ үед нөхөр Буяннэмэх огт хоосон байсан бус бөгөөд ард түмний мэдрэл хөгжлийг улам дээшлүүлэх ба бас ч хувьсгалын бөгөөд үндэсний чанартай уран зохиол, уран сайхныг дэлгэрүүлэн хөгжүүлэхийн үүднээс ихээхэн анхаарлыг тавин оролдож байсны тул анхдугаар уран сайхны үдшийг анх үүсгэж, Ленин клубд явуулсан ба бас “арван жил” хэмээх их жүжгийн зохиол хийгээд “ядуу бидний сэнхрэл” гэх мэт шүлэг ба бас хэд хэдэн жүжиг зохиолуудыг бичсэн ажээ”¹³ гэж бодит байдалд нийцүүлэн хураангуйлан дүгнээд, тухай үед монголын уран зохиол нь барууны хэлбэрэл ба зүүний нугалаатны хор уршигаар зохих хөгжлөө олж чадсангүй. С. Буяннэмэх ч гэсэн урлагийн өндөр түвшинтэй шинэ зохиолын зүйлийг бичиж туурвиж чадсангүй. Хэдий тийм боловч С. Буяннэмэх нь зүгээр хоосон байсангүй, ард түмний мэдрэл хөгжлийг улам дээшлүүлэхийн төлөө хувьсгалын ба үндэсний чанартай уран зохиол, уран сайхныг дэлгэрүүлэн хөгжүүлэх зорилгоор анхдугаар уран сайхны үдшийг анх үүсгэн зохион байгуулж, Ленин клубд тавьсан бөгөөд “Арван жил”¹⁴ хэмээх жүжиг, “Ядуу бидний сэнхрэл”¹⁵ хэмээх шүлгийг зохиож, анхдугаар үе ба хоёрдугаар үед бичсэн зохиолудын дээжээ “Уран үгсийн чуулган”¹⁶ хэмээх зохиолын эмхтгэлд оруулж хэвлүүлсэн тухай мэдээлэн өгүүлжээ.

С.Буяннэмэхийн уран зохиолын гуравдугаар үе (1932-1935 он) -ийн тухай өгүүлэхдээ “Энэхүү гуравдугаар үе нь түүхт шинэ эргэлтээс эхэлж өдгөө хүртэлх үе бөгөөд энэ үеийг нөхөр Буяннэмэхийн уран авьяас нь ундарч буй булаг мэт оргилж, үндэсний хувьсгалын чадамгай уран зохиолч мөн хэмээн биеэ таниулсан үе хэмээхээс арай хэтрэхгүй буй за. Энэ үеийг нөхөр Буяннэмэх нь өөрийн сайн сайхан зохиолуудыг зохиосны дээр үндэсний уран сайхан ба уран зохиолыг хөгжүүлэх ба шинэ шинэ уран авьяастныг төрүүлж гаргахын тул маш их ажлыг гүйцэтгэсэн нь хэн бүхний өмнө илэрхий болой”¹⁷ гэжээ. Энд ярьж байгаа “Түүхт шинэ эргэлт” гэдэг нь юу вэ? гэвэл 1932 оны 6 дугаар сард хуралдсан Монгол ардын хувьсгалт намын төв хороо ба төв хянан байцаах комиссын хамтарсан онц бүгд хурлаас “Зүүн”-ний нугалаатаны бодлогыг шууд буруушааж, төв хорооны бүрэлдхүүнээс “Зүүн”-ний нугалаатан Шижээ, Бадрах, Дэндэв нарыг хөөж гаргав. Тус бүгд хурлаас тэр үеийн Монгол ардын хувьсгалт намын үндсэн зорилтыг тодорхойлж, тэдгээр зорилтыг шийдвэрлэхийн тул “Шинэ эргэлтийн бодлого” гэж алдаршсан арга хэмжээний хөтөлбөрийг төлөвлөж бодитой хэрэгжүүлэв. Энэ нь түүхэн дээр шинэ эргэлтийн бодлого гэж алдаршсан юм. Зохиолчоос С. Буяннэмэхийн уран бүтээлийн гуравдугаар үеийг маш чухал үе хэмээн дүгнэж, энэ үе бол С. Буяннэмэхийн “Уран авьяас нь ундарч буй булаг оргилж”,

¹³ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй” Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2000 он. 23-24 дүгээр нүүр

¹⁴ С.Буяннэмэх “Арван жил” хэмээх жүжиг, тус жүжгийн уг эх олдоогүй.

¹⁵ С.Буяннэмэх “Ядуу бидний сэнхрэл” гэх шүлэг, Монгол улсын “Залуу Гварт” сэтгүүлийн 1931 оны 9 дүгээрт нийтлэгдэв. Ван Мандуга Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1 дүгээр боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он. 96-99 дүгээр нүүр.

¹⁶ С.Буяннэмэх “Уран үгсийн чуулган” хэмээх зохиолын эмхтгэл, хувьсгалын уран зохиолч нарын бүлгэмээс хэвлүүлэв. 1929 оны 12 дугаар сард.

¹⁷ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй” Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. 2000 он. 24 дүгээр нүүр

“Үндэсний хувьсгалын гарамгай уран зохиолч”-оор тодорсон, “өөрийн сайн сайхан зохиолоо зохиосон”, “шинэ шинэ залуу уран авьяастныг төрүүлж гаргахын тул их ажлыг гүйцэтгэсэн” үе гэж гүйцэт үнэлжээ. С. Буяннэмэх тус хугацаанд зохиосон том хэмжээний жүжгийн зохиол “Шөнийн буг”¹⁸, “Харанхуй засаг”¹⁹, “Эрдэнэт соёмбын эзэн эрэлхэг жанжин Сүхбаатар”²⁰ зэргийг Монгол улсын дотор нэрд гарсан зохиол бөгөөд монгол үндэсний ший жүжгийн зохиолын анхны үүдийг нээж өгсөн зүйлүүд мөн гэж үзжээ. Бас “Угтан биелүүлэгтүн”²¹, “Мэндэгсэн хүний үлгэр”²², “Гэв гэнэт эвэр ургавуу”²³, “Архи”²⁴, “Залуу нөхөд та нарт сануулга болгоё”²⁵, “Хулгай замбал”²⁶, “Жинчин Пүрэвийн жигтэй явдал”²⁷, “Их тэнгэрийн дүлий”²⁸, “Бүтэлгүй Гомбын маргааш”²⁹ гэх зэрэг уран бүтээлийг нь нэр дурдан авч үзээд, “Ерийн Буяннэмэхийн

¹⁸ С.Буяннэмэх “Шөнийн буг” жүжиг, 1933 оны эхээр театрт тавьж, 1934 онд тусгай товхимол болгож хэвлүүлэв. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1 дүгээр боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он. 733-766 дугаар нүүр

¹⁹ С.Буяннэмэх “Харанхуй засаг” жүжиг, 1933 оны 3-р сард бичиж театрт тавив. 1934 онд Монгол улсын ардыг гэгээрүүлэх яамнаас тусгай товхимол болгон хэвлүүлэв. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1 дүгээр боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он. 766-795 дугаар нүүр.

²⁰ С.Буяннэмэх “Эрдэнэт соёмбын эзэн эрэлхэг жанжин Сүхбаатар” жүжиг, Улаанбаатараас олдсон монгол бичгийн машиндмал эх, зохиогдсон бодитой он тодорхоогүй. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1 дүгээр боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он. 796-862 дугаар нүүр.

²¹ С.Буяннэмэх “Угтан биелүүлэгтүн” шүлэг, “Монгол ардын үндэсний соёлын зам” сэтгүүл, 1934 оны 1-р хугацаа. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он. 293-294 дугаар нүүр.

²² С.Буяннэмэх “Мэндэгсэн хүний байдал” нийтлэл, “Монгол хэлний яруу найруулга” (Дунд сургуулиудад үзэмой) Ардыг гэгээрүүлэх яамны хэвлэл, 1934 он. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (II дүгээр боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2009 он. 326-329 дүгээр нүүр.

²³ С.Буяннэмэх “Гэв гэнэт эвэр ургавуу” шүлэг, “Ардын үндэсний эрх” сонин, 1933 оны 82 (115)-р номер. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он, 121-126 дугаар нүүр.

²⁴ С.Буяннэмэх “Архи” шүлэг, “Уран үгсийн чуулган” 1929 он. “Үнэн” сонины 1929 оны 21 (163)-р номерт “Энэ нь юун буй эрхэм авгай нар уншмагц мэдэх бөгөөд энгийн цагт зугаа болгомуу” гэх нэрээр нийтлэв. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он, 73-74 дүгээр нүүр.

²⁵ С.Буяннэмэх “Залуу нөхөд та нарт сануулга болгоё” шүлэг, “Холбоо шүлгийн цомирлог” түүвэр, Ардыг гэгээрүүлэх яамны хэвлэл, 1935 он, Уул гарчиг нь “Сайнд нь сануулга, самуунд нь цээрлэл- залуучуудаа сануулга болгоё” гэдэг. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он, 219-222 дугаар нүүр.

²⁶ С.Буяннэмэх “Хулгай замбал” шүлэг, “Холбоо шүлгийн цомирлог” түүвэр, Ардыг гэгээрүүлэх яамны хэвлэл, 1935 он. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он, 267-268 дугаар нүүр.

²⁷ С.Буяннэмэх “Жинчин Пүрэвийн жигтэй” үлгэр, “Монгол ардын үндэсний соёлын зам” сэтгүүл, 1934 оны 4-р хугацаа. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (2-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2009 он, 248-253 дугаар нүүр

²⁸ С.Буяннэмэх “Их тэнгэрийн дүлий” өгүүллэг, “Монгол ардын үндэсний соёлын зам” сэтгүүл, 1935 оны 5-6-р хугацаа. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (2-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2009 он, 254-264 дүгээр нүүр

²⁹ С.Буяннэмэх “Бүтэлгүй Гомбын маргааш” үлгэр, “Ардын үндэсний эрх” сонин, 1933 оны 68 (101)-р номер. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (2-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2009 он, 242-247 дугаар нүүр

бүхий л зохиолуудыг авч үзвээс хэзээд ардын зоригийн агуу хүчтэй болохыг илрүүлэн тодорхойлж түүний жавхлант сүрийг бадруулан хуучны бүдүүлэг заншил хүнд сурталтан алия ганган завхайчуудын зэрэг улсын хөгжилд ба ард түмний аж ахуйд тусгүй, хор саад бологч зүйлүүдтэй хайр гамгүйгээр тэмцэж ард түмнийг хувьсгалын соёлоор хүмүүжүүлэн шинэ хүнийг гаргах ба хувьсгалын ололт хөгжилт хийгээд түүний ач гавьяаг ард олонд мэдрүүлэхийг эрмэлзсэн байна.”³⁰ гэж С. Буяннэмэхийн зохиолын утга, сэдэв, агуулга, үзэл санаа, үзэл сурталч чанарын талаар маш өндөр үнэлж цэгнэсэн байна. Бас “Уран хошин шатарч”³¹, “Хөөрхөн тодийн өгүүлэл”³², “Уран хошин хуурч”³³, “Ардын эрхт манай төр нь амар жаргалант сайхан”³⁴ зэрэг шүлэг зохиолыг нь онц сонирхолтой зүйл гэж үзээд, эдгээр нь “Хоосон алия наадам төдий нүүр угаах зэрэг бус, ихээхэн улс төрийн чанартай зүйл мөн”³⁵ гэжээ. Бас “Ардын эрхт манай төр нь амар жаргалант сайхан” гэдэг шүлгийг нь зарим хүмүүс “олон монголтой юм хэмээн нэрлэнэ” гэж, шүлгийн мөр бадагт “монгол” гэх үсэг олонтоо давтагдаж байсан тухай мэдээлээд, энэ нь онц сонирхолтой зүйл болноо гэж өгүүлжээ. Тус шүлгийн эхний хэдэн бадгийг сийрүүлбэл:

“Ардын эрхт манай төр нь амар жаргалант сайхан
 Ард түмэнтэй найрлан суух радио уран сайхан
 Ашдын эрдэм улсын соёлыг хөгжүүлж мандуулах сайхан
 Ард түмэн бид бүгдээр баясч суух нь сайхан
 Монгол улс хувьсгалт төрийг мандуулснаас нааш
 Монгол хэмээх үндсэн соёлоо сэргээн хөгжүүлэх болов
 Монгол хэмээх үндсэн соёл нь хөгжөөд ирэхийн хамтаар
 Монголын дотор шинэ явдал өдөр дараалан үүсэв
 Ший жүжиг, тоглоом наадам монгол маягаар тоглов
 Шалгарсан сайн алдартай дуучид монгол дуугаа дуулав
 Шанз хуучир дөрвөн чавхдас монгол янзаар хөглөв
 Шинэхэн янзаар хувьсгалт ёсны монголын авьяас сэргэв

³⁰ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он 25-дугаар нүүр

³¹ С.Буяннэмэх “Уран хошин шатарч” шүлэг, уг гарчиг нь “Уран хошин шатар”, “Холбоо шүлгийн цомирлог” түүвэр, Ардыг гэгээрүүлэх яамны хэвлэл, 1935 он. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он, 289-293 дугаар нүүр.

³² С.Буяннэмэх “Хөөрхөн тодийн өгүүлэл” шүлэг, “Холбоо шүлгийн цомирлог” түүвэр, Ардыг гэгээрүүлэх яамны хэвлэл, 1935 он. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он, 268-271 дүгээр нүүр.

³³ С.Буяннэмэх “Уран хошин хуурч” шүлэг, уг гарчиг нь “Уран хошин захын хуурч” гэдэг, “Холбоо шүлгийн цомирлог” түүвэр, Ардыг гэгээрүүлэх яамны хэвлэл, 1935 он. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он, 274-282 дугаар нүүр.

³⁴ С. Буяннэмэх “Ардын эрхт манай төр нь амар жаргалант сайхан” шүлэг, 1935 онд ардыг гэгээрүүлэх яамнаас хэвлэсэн “Холбоо шүлгийн цомирлог” түүвэрт “Үргэлжлэн дэлгэрч байгаа үндэсний уран сайхан” нэртэй нийтлэгдэв. Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он, 129-131 дүгээр нүүр.

³⁵ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он 25 дугаар нүүр

Холбоо шүлгүүд намираад гарах нь өөрийн хэлний монгол
 Хослуулаад зохиосон эгшигт дууны үг санаа нь монгол
 Хойшид боловсрох соёлын зам дээр үндэс болгох нь монгол
 Хуучин ёсны Азийн дундаас шинэ мандсан монгол
 Олон түмэн монгол ардын идэр залуу дүү нар
 Ухаан сэхээт монгол овгийн уран сайхны авьяас
 Өөрийн болох монгол улсыг мандаж бадрахыг хүсэж
 Үндэсний эрдэм монголын соёлыг өөд нь татахаар зоривой
 Энэ өдөр манай Монголд үндсэн соёл хөгжив
 Энэ дэлхийд манай монголын нэр алдар нь сэргэв
 Эрдмийг хүссэн манай монголын бичгийн ардууд хуралдав
 Эвдэрч хэмхэрсэн манай монголын бичиг зохиолоо сэлбэв
 Шинэ ёсны шинжилхүйн ухаан монгол оронд ирэв
 Шалгарсан ёсны үнэн эрдмийг монгол соёлоор угтана
 Шилж олсон хувьсгалын журмыг монгол соёлдоо шингээж
 Сэргэж боссон идэр залуу монгол бид нар суралцана”³⁶ гэж шүлэглэжээ.

С.Буяннэмэх тус шүлэгтээ монгол шүлгийн айзам цогцлолтын онцлогийг гайхалтай сайхан илрүүлж, хэлбэрийн гоо сайхныг чадамгай бүтээлчээр, уян хатан хувиралт ихтэй мөртлөө маш нарийн жигд жам хуультай дэлгэн үзүүлжээ. Жишээлбэл, “Монгол” гэх нэгэн үсгийг шүлгийн олон мөр шадад ахин дахин давтахдаа маш урлаг мөртөө ухаалаг зохицуулж, урлагийн сонирхолыг татах хүчнийг чангаруулж чадсан байна. “Монгол” гэх нэгэн үсгийг хоёрдугаар бадгийн дөрвөн шадын эхэнд жигд давтаж, гуравдугаар, долдугаар бадгийн найман шадын гуравдугаар нугалбарт жигд давтаж, дөрөвдүгээр бадгийн дөрвөн шадын адагт жигд давтаж, тавдугаар, зургадугаар бадгийн найман шадын хоёрдугаар нугалбарт жигд давтсан байна. Ингэж дөрвөн мөрт зургаан бадаг шүлэгт “Монгол” гэх нэгэн үсгийг 24 удаа давтаж, монгол шүлгийн хэлбэрийн гайхамшигийг нийт олонд алдаршуулан сонирхуулсан байна.

С.Буяннэмэх үндэсний уран сайхан, уран зохиолыг хөгжүүлэх ба шинэ уран авьяастныг хүмүүжүүлэн боловсруулах, үндэсний соёлыг хөгжүүлэн дэлгэрүүлэх ба хувьсгалын урлаг утга зохиолыг олон нийтэд таниулж дур хүслийг нь татахын тул цөхрөшгүй чармайж хүчин зүтгэж байжээ. Тэрбээр уран зохиолчдын холбоог удирдан байгуулж, “Уран сайхны олон нийтийн үдэш”, “Уран сайхны холбоо шүлгийн радио эгшигт үдэш” зэргийг удаа дараагаар үүсгэн явуулж, уянга эгшиг бүхий шүлэглэл ба уран хошин инээдмээр олон түмнийг сонирхуулж, монголын хувьсгалт шинэ соёл урлагийг хөгжүүлэх үйлст уйгагүй зүтгэж жинтэй хувь нэмрээ оруулсан болохыг зохиогчоос зөв зүйтэй үнэлжээ.

Тус өгүүллийн ард тэмдэглэсэн “Төгсгөлийн өгүүлэл”-д С. Буяннэмэх чухам аль улс орны хүн болох тухай гурван зүйлийн адил бус үзэлт байжээ, тухайлбал, зарим хүмүүс түүнийг дотоод монгол гэж зарим нь буриад монгол гэж, зарим нь монгол улсын хүн гэж үздэг байв. Зохиолчоос “нөхөр Буяннэмэх болвоос Өмнөговь аймгийн Дэлгэрхангайд нутагтай, Сономбалжир хэмээх хүний ахмад хөвгүүн бөгөөд түүний эцэг нь одоо хүртэл буйн дээр түүний олон дүү нар нь одоо ч байсаар болой. Харин Буяннэмэх болвоос 1901 онд төрж бага наснаас эхлэн хэд хэдэн ачтан хүмүүсийн гарыг

³⁶ Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он, 129-130 дугаар нүүр

дамжиж өсч хүмүүжсээр хорь шахам нас хүртэл нилээд олон аав ээжтэй болсон...³⁷ гэж С. Буяннэмэхийн намтар түүхд холбогдсон чухал мэдээг гаргажээ. Зохиогчоос бидэнд С. Буяннэмэх бол Өмнөговь аймгийн Дэлгэрхангай сум (тухайн үед Дэлгэрхангай сум нь Өмнөговь аймгийн харьяанд байжээ)-д нутагтай Сономбалжир³⁸-ын ахмад хөвгүүн болж 1901 онд төрсөн, бага наснаасаа эхлэн хорь шахам нас хүртлээ хэд хэдэн ачтан хүмүүсийн гар дээр өсч хүмүүжиж, нилээд хэдэн аав ээжтэй болсон, 1935 оны үеэр түүний эцэг Сономбалжир энх тунх байсан ба түүний олон дүү нар³⁹ нь ч эсэн мэнд байсан тухай баттай мэдээг хангаж өгсөн байна. Энэ баримтыг үндэслэвэл С.Буяннэмэх нь дотоод монгол, буриад монгол аль нь ч биш Монгол улсын иргэн болох нь мадаггүй. Тэр нь 1902 онд төрсөн бус, харин 1901 онд төрсөн гэдэг нь үнэний үндэслэлтэй болж байгааг давхар баталж байна.

Хоёрт, тус өгүүлэлд “Буяннэмэхийг эсэргүүцэн зангач дайсан болвоос манай хувьсгалын дайсан бөгөөд тэд нараас түүнийг элдвээр муучлахыг хичээж эсэргүүцэж хавчиж цохисоор ирсэн түүхтэй боловч бас тус улсын ард түмний эрх чөлөө, эрдэм соёлыг амь мэт хамгаалан дарагдашгүй тэмцээр ирсэн нь үндэсний хувьсгалаар хүмүүжсэн манай олон нөхдийн өмнө илрэхийн дээр түүний зохиолуудын дотор ч илрэх бөлгөө.”⁴⁰ гэж дурдаад, С. Буяннэмэхийн шүлэг зохиол дэх “Түмэн ардын эрх чөлөөг сэтгэл зүрхэнд бясалгаж цаг үргэлжид түүний төлөөнөө соёлын бүтээлийг бүтээнэ. Харанхуй дайсан хажуу талаас мунхаг шижмээр хүлэвч үнэн эрдэм гэгээн дөлөөр тас цохиж чадна.”⁴¹ “Мандаж байгаа манай ардыг гагцхүү занатай дайсан, мартаж болохгүй хажуу талд хардаж муулсаар байна, Муулав муулав, хардав хардав яаж чаднаа тэд нар, манай ёс манай эрдэм үнэний үндэс мөн”⁴² гэсэн хоёр хэсэг шүлгийн өгүүлэмжээр түүний түмэн ардынхаа төлөө соёлын бүтээлийг бүтээхээр эрэлхэг хатан зоригоор цуцалтгүй тэмцэж байсан зориг санааг магтан сайшаахын хамт “Үнэний төлөө оролдсон нь хэзээ ч үнэнээ олж чаддаг ажгуу”⁴³ хэмээн дүгнэжээ. Бид

³⁷ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он, 26 дугаар нүүр

³⁸ Сономбалжир- Буяннэмэхийн төрсөн эцэг, Түшээт хан аймгийн Говь түшээ гүнгийн хошууны харьяат Жимэ гэлэн гэгч хүний ганц хөвгүүн. Сономбалжир доороо Цэрэндэжид, Пэлжид, Оролжид хэмээх гурван охин дүүтэй. Энэ хүн багадаа тулганы халуун нурманд гараараа дарж унаад гарынхаа хурууг түлчихээд, эрхийгээс бусад дөрвөн хуруу нь барилдан нийлж хөдөлгөөн муутай болж, нутаг усандаа мухар Сономбалжир гэж нэрлэгдэв. Морь сайн уургалдаг, бутны үндсээр уран нарийлаг сийлсэн шатар нь одоо ч үр садныханд нь хадгалагдаж бий. Амьдрал нь нилээд чинээлэг, арван лангийн бэнтэй хэт хутга зүүж явдаг байсан гэнэ. 1901 оны үеэр тус нутгийн Харлаг Цогт гэх хүнийд орж гарч байснаа Цогтын охин Думаатай нэгэн хүү гаргасан нь Буяннэмэх аж. Гэвч Думаатай жинхэнэ гэрлэж суусангүй. Дараа нь Цэрэндолгор (1881-1966) гэгчтэй ураглаж, зургаан хүү, нэг охинтой өнөр өтгөн айл болжээ. 1947 оны үеэр нас баржээ.

³⁹ С.Буяннэмэхийн эцэг нэг, эх өөр дүү нар 7 бий, үүнд Сумъяадорж, Цэрэндорж, Адъяабазар, Цэвээнжав (1914-?), Даваадорж(?-1985), Гомбодорж(1921-1988) гэх зургаан хүү дүү, Адъяадорж (1910-1970) гэх нэгэн охин дүүтэй аж. Сумъяадорж, Адъяадорж, Гомбодорж нарын үр сад нилээд олон байгаа бөгөөд одоо эсэн мэнд аж төрөн амьдарч байна.

⁴⁰ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он, 25 дугаар нүүр, 26 дугаар нүүр

⁴¹ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он 26-27 дугаар нүүр

⁴² Ван Мандуга, Д. Цэдэвийн харгуулан найруулсан “Сономбалжирын Буяннэмэх” (1-р боть), Үндэсний хэвлэлийн хороо, 2008 он, 129-130 дугаар нүүр, 131 дүгээр нүүр.

⁴³ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он, 27-28-р нүүр

түүхэн үнэний мөрөөр мөшгиж нарийн хянуур ажиглаж үзвэл, 1924 оны монгол ардын намын гуравдугаар их хурлаас нааш 1932 оны түүхт шинэ эргэлтийн бодлогын үе хүртэл, С.Буяннэмэх нь баруун зүүний нугалаа завхралд удаа дараалан өртсөөр ирсэн бөгөөд улс төрийн хилс хэлмэгдлээр данзантан хэмээгдэж нэг сар шоронд хоригдож, Ринчиннов нарын хатуу хардлага хавчлагаас эвлэлийн төв хорооны даргын тушаалаа хасуулж Барга өвөр монголд аюулаас зайлж дүрвэж гарсанаас “оргодол” гэж шүүмжлэгдэх болжээ. Намын зургадугаар их хурлын хоёрдугаар, гуравдугаар бүгд хурлын үеэр баруунтан хэмээн шүүмжлэгдэж, долдугаар их хурал дээр намын төв хорооны гишүүнээ хасуулж, дараа нь Улаанбаатар хотын намын хорооны даргын тушаалаас огцруулав. Намын хоёрдугаар шалгалтын дараахан намаас хөөгдөж, хувьсгалын түүхийн музейн эрхлэгчээ хасуулж, ажлаасаа хөөгджээ. 1932 оны үеэр тодорхой шалтгаан үгүйгээр дотоодын хамгаалах газрын харанхуй шоронд зургаан сар хоригдсон байжээ. Шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлсний дараа, тэрээр 1933 оноос “Ардын эрх” сонины хариуцлагатай найруулагч болж, 1934 оноос эхлэн Монголын уран зохиолчдын товчоон даргаар томилогдож, “Монгол ардын үндэсний соёлын зам” сэтгүүлийн коллегийн гишүүнээр ажиллаж эхэлсэн бөгөөд 1935 онд Улсын гавьяат алдарт уран зохиолч цолоор шагнагдаж, нам засгийн шагнал хөхүүллийг удаа дараалан тосч, нийгэм олон нийтийн дунд нэр хүнд нь өндөржиж, түмэн олны талархал хүрээллийг хүлээсэн байжээ. С.Буяннэмэхийн иймэрхүү энхэл тунхал амьдралын замнал, гашуун хошуун улс төрийн хувь тавилан, бэрх бартаат урлагийн замналыг биечлэн ойлгож байсан санаа заяа нэгтэй уран зохиолч нөхөд нь түүнийг өмгөөлөн төв голч үг хэлж, “Буяннэмэхийг эсэргүүцэн зангах дайсан болвоос манай хувьсгалын дайсан мөн.” гэж хашгирчээ. Энэ үг нь тухайн үеийн нэг бүлэг хүмүүсийн сэтгэлийн дуун болох бөгөөд өнөөдрийн уншигч судлагч нарт юу нэгийг гүн сэтгүүлж байгаа аж.

Гуравт, С. Буяннэмэх бол монгол уран зохиолын түүхэнд урьдахыг залгамжилж хойнохийг нээсэн, монголын шинэ үеийн хувьсгалын уран зохиолыг анхан үүсгэгч мөн гэж тодорхойлоод, түүний уран бүтээлийн урлаг уран сайхны амжилтыг өндөр үнэлжээ. Бодитой өгүүлэхдээ “Ерөөс урьдын хуучин үеийн монголын уран найруулгуудын ихэнх нь зүйрлэлийн чанартай буюу эс бөгөөс шашин мөргөлийн байдалд холбогдсон худал хуурмаг зохиолууд байсан мэт бөгөөд түүнээс хойш 11 оноос (1921 он-шлэгчээс) эхлэн манай анхны уран зохиолч нөхөр Буяннэмэхийн элдэв зохиолууд үргэлжилсэн амой. Эл нөхрийн зохиосон уянгат сайхан шүлэг эгшиг тэргүүлэн сонин бахтай үлгэр оньсого зэргийг уншиж үзсэн үнэнч ард бүхэн түүний сайхан чанар гүн утгыг магтан сайшааж ямар гашуун зовлонтой боловч нэгэн удаа инээн баярлах бөгөөд хэдий хүчгүй боловч зориглон босох мэт гайхамшиг сонин байдлууд тэдний дотор төрдөг аж. Ерөөс нөхөр Буяннэмэх уран зохиол бичихдээ үнэн байдлыг олж чаддаг ба гайхамшигт яруу гоёмсог үгнүүдийг олонтоо хэрэглэн чадах ба сэдэв үүсгэлийг олохдоо мэргэн тул чухам ямар юманд зориулан үйлдэгдсэн болвоос түүндээ тавтай зохилдон чаддаг болой.”⁴⁴ гэж, 1921 оны хувьсгалаас өмнөх монгол уран зохиолын олонхи нь зүйрлэлийн чанартай зохиол буюу шашин мөргөлийн байдалд холбогдсон зохиол, 1921 оноос хувьсгалын анхны уран зохиолч С.Буяннэмэхийн зохиол бүтээл зохиогдож эхэлжээ гэж үзээд, С.Буяннэмэхийн “Уянгат сайхан шүлэг эгшиг”, “Сонин бахтай үлгэр оньсого”-нууд нь хүмүүсийг хөхөөн зоригжуулж, гоо сайхны хав цэнгэл олгох нийгмийн үйлдлээр их

⁴⁴ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он 28 дугаар нүүр

байдаг гэж тодорхойлжээ. Бас С. Буяннэмэх уран зохиол бичихдээ “Уран байдал”-ыг олж чаддаг, “гайхамшигт яруу гоёмсог” уран үгийг олон хэрэглэдэг, “сэдэв үүсгэл”-ийг олохдоо мэргэн байдаг, уран мэргэшил болон гаргах гэсэн утга санаа хоёр нь хавлиг сайхан зохилдож чаддаг зэрэг урлаг уран сайхны ур мэргэжлийг нь бишрэн бахдаж өндөр үнэлсэн байна.

Дөрөвт, тус өгүүллийг бичсэн зорилго болон зохиогчийн тухай товч дөхөм тушаажээ. Зорилгын тухай ярихдаа: “нөхөр Буяннэмэх нь монголын олон ардын дотроос уран авьяастан нөхдөө уриалан нэгтгэж зохистойгоор удирдан уран сайхныг машид хөгжүүлсүгэй хэмээх зориг хүсэл үнэн санаа бүрэн бөгөөд эрс аж. Ямагт энэ мэтээр зүтгэн оролдогч анхны зохиолчийн байдлаас товчхон бүлгийг тэмдэглэн олон зохиолчид ба ард түмэнд таниулсугай хэмээнэ”⁴⁵ гэжээ. 1934 оны 10 сараас эхлэн С.Буяннэмэх нь Монголын үндэсний хувьсгалын уран зохиолчдын холбооны товчоон даргын тушаалыг хариуцаж⁴⁶ монголын үндэсний хувьсгалын уран зохиолыг улам цаашид дэлгэрүүлэн хөгжүүлэхийн төлөө, оюун санаа хүчин чадлаа шавхаж, уран авьяастан нөхдөө удирдан дайчилж, олон зүйлийн бодит үйл ажиллагаа зохион байгуулж шуурхай зүтгэж байжээ. Энэ өгүүллийг голдуу С.Буяннэмэхийн зүтгэл чармайлгыг олон зохиолчид ба ард олонд нэн гүнзгий таниулахын төлөө бичсэн нь тодорхой.

Өгүүллийн эцэст “анхны урлал ардын төлөө булаг адил ундармой, түүний удирдагчийн үнэн санаа хэн бүхнээ танигдав. Авьяастан нөхөд анхааран толилж улам бат болгохыг өчүүхэн гишүүд хүсэн хүсч зурвас бүлгийг бичив.”⁴⁷ гэж дөрвөн мөр шүлэг бичиж зохиогчийн нэрээ “өчүүхэн гишүүд” гэж нууцгайлан тэмдэглэжээ. Энэ өчүүхэн гишүүд нь монголын үндэсний хувьсгалын уран зохиолчдын холбооны “гишүүд” болох нь дамжиггүй боловч чухам хэн хэн болох нь одоохондоо тодорхой бус, хойшид шинэ материалаар нээн илрүүлэх ажил шаардагдаж буй.

Хураангуйлвал, тус өгүүллэл бол С. Буяннэмэхийн уран бүтээлийн зохиол туурвилыг үечлэн хуваах гэсэн хамгийн анхны оролдлого болно. Хэдийгээр Монголын нийгмийн хөгжил хувирал ба улс төрийн үйл ажиллагааны онцлог байдлаар гол үндэслэл болгож үе шат хуваасан нь уран бүтээлийн тус биеийн урлаг уран сайхны онцлог, ур чадварын өсөлт зэрэг талыг хөнгөвчилж учир дутагдалтай боловч, 1921-1935 он болтолх 15 жилийн хугацаан дэх С. Буяннэмэхийн уран бүтээлийн зохиол туурвилын ажиллагааг 1921-1928 он, 1928-1932 он, 1932-1935 он хэмээх гурван үе шатанд хувааж хянуур ажиглалт хийж, түүний стил бүрийн уран бүтээлийн утга сэдэв, агуулга үзэл санаа ба урлаг уран сайхны амжилт ололтыг өндөр үнэлж, монголын хувьсгалт урлаг соёл, уран зохиолыг хөгжүүлэн дэлгэрүүлэх үйлст түүний оруулсан чухал хувь нэмрийг төв голчоор үнэлэн дүгнэсэн нь сайшаалтай. Энэ нь С. Буяннэмэх жич түүний уран бүтээлийн тухай судалгааг гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдол бүхий анхны баримт материал болохоороо эрдэм шинжилгээний өндөр үнэ цэнэ бүхий бүтээл болох юм.

⁴⁵ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он, 28-р нүүр

⁴⁶ “Бүх гишүүдийн хэрэг хэлэлцэх хурлын тогтоол”, Монгол улсын нийтийн номын санд хадгалагдаж байгаа “С. Буяннэмэхийн хавтаст хэрэг”-т байх С. Буяннэмэхийн гар бичмэл эх

⁴⁷ Ван Мандугагийн найруулсан “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2004 он, 28-р нүүр

SUMMARY

The author judged few questions about works and biography of S.Buyannemekh from the works published in 1929 and 1935. According to these investigations, S.Buyannemekh was a great figure of the beginning period of modern Mongolian literature.